

2019 оны 4.. сарын 29 өдөр

Дугаар № 19/02

Улаанбаатар хот

## Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “МИК Холдинг” ХК-ийн дүрмийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ**:

1. “МИК Холдинг” ХК-ийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

1.1 Дүрмийн дараах хэсгийг өөрчлөх:

- 1.1.1. 2.2-т “Улаанбаатар хот, Монгол улс, ..., 10-р давхар” гэснийг “Монгол улс, Улаанбаатар хот, ..., 13-р давхар” гэж;
- 1.1.2. 8.3.8-д “*Нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;*” гэснийг “*Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;*” гэж;
- 1.1.3. 8.3.9-т “*Компанийн өөрийн хувьцаагаар солих,...*” гэснийг “*Компанийн өрийг хувьцаагаар солих,...*” гэж;
- 1.1.4. 9.4-т “...дахин сонгоно.” гэснийг “...нөхөн сонгоно.” гэж;
- 1.1.5. 9.6-д “*ТҮЗ-ийн гишүүнийг хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгох...*” гэснийг “...ТҮЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох...” гэж;
- 1.1.6. 9.7.3-т “*Компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;*” гэснийг “*Компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;*” гэж;
- 1.1.7. 16.2-т “*Дотоод аудит нь компанийн үндсэн үйл ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүүгийн бүртгэл, эрх зүйн мэдлэг, турилагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТҮЗ-аас баталсан Дотоод хяналтын хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.*” гэснийг “*Дотоод аудитын нэгж нь компанийн үндсэн үйл ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүүгийн бүртгэл, эрх зүйн мэдлэг, турилагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд нэгжийн үйл ажиллагаатай холбоотой журмыг ТҮЗ-өөс батална.*” гэж;
- 1.1.8. 16.3-т “*Компанийн өдөр тутмын удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТҮЗ-ийн томилсон дотоод аудит нь хэрэгжүүлнэ.*” гэснийг “*Компанийн өдөр тутмын удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТҮЗ-өөс томилогдсон дотоод аудитын нэгж буюу дотоод аудитор хэрэгжүүлнэ.*” гэж;
- 1.1.9. 16.4-т “*Дотоод аудит нь компанийн ажилтан албан хаагчдын ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй байна.*” гэснийг “*Дотоод аудитор нь компанийн ажилтны ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй байна.*” гэж;
- 1.1.10. 16.5-д “*Дотоод аудитын албанаас...*” гэснийг “*Дотоод аудитын нэгжээс...*”, Гүйцэтгэх захирлын даалгавраар ТҮЗ-ийн тэдний баталсан...” гэснийг “*Гүйцэтгэх удирдлагын даалгавраар ТҮЗ-ийн баталсан...*” гэж;
- 1.1.11. 21.7-д “...дийлэнх олонхын саналаар...” гэснийг “...олонхийн саналаар...” гэж;

1.1.12. 24.6-д “Хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашигийг ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигч бүрээр...” гэснийг “Ногдол ашигаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашигийг...” гэж.

1.2 Дүрмийн дараах хэсэгт нэмэлт оруулах:

- 1.2.1. 8.4-т “Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үнд:” гэж;
- 1.2.2. 8.3.7-8.3.20 дахь заалтыг 8.4.1-8.4.14 гэж;
- 1.2.3. 9.7.21-т “...чиглэлээр...” гэсний дараа “хараат буюу” гэж;
- 1.2.4. 14.1-т “...ажиллуулж...” гэсний дараа “болов бөгөөд тус хороо нь компанийн хараат буюу охин компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үргийг хэрэгжүүлж, шийдвэр гаргах эрхтэй байна.” гэж.

1.3. Дүрмийн дараах хэсгээс хасах:

- 1.3.1. 8.6.2-т “...тодорхой хугацаа заагаагүй бол...” гэснийг;
  - 1.3.2. 14, 14.1, 14.2, 14.4-т тус тус “...дэд...” гэснийг;
  - 1.3.3. 15.5-т “...хөлсөөр ажиллах гэрээний...” гэснээс “...хөлсөөр ажиллах...” гэснийг;
  - 1.3.4. 16.6.4-т “Аудитын гэрээгээр тодорхойлсон бусад мэдээллийд.” гэснийг;
  - 1.3.5. 22.10-т “Компанийн эрх бүхий албан тушаалтананд хариуцлага хулээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.” гэснийг;
  - 1.3.6. 24.1-т “...хувьцаа бүрийн хувьд....” гэснийг;
  - 1.3.7. 24.7-д “Хувьцаат ... гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо...” гэснийг;
  - 1.3.8. 26.3-т “Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид санал нэгтэйгээр шийдвэрлэнэ.” гэснийг.
2. Энэ тогтоолын 1-т заасан нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж хянуулах, улсын бүртгэлд бүртгүүлэхийг “МИК Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
  3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (М.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



М.МӨНХБААТАР